САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

АРВАННЭГДҮГЭЭР САР 2018

ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт

ДНБ
6.4%
2018 оны III-р улирлын байдлаар

ИНФЛЯЦИ
8.1%

ТӨГРӨГИЙН АМ.ДОЛЛАРТАЙ ХАРЬЦАХ ХАНШ
2581.88 төг

ТӨСВИЙН АЛДАГДАЛ
266 тэрбум төг

ГАДААД ХУДАЛДАА
1109 сая АМ.ДОЛЛАР

ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.





Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт

ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ
3.4 ТЭРБУМ ДОЛЛАР

ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХУВЬ
12.3%

НИЙТ ХАДГАЛАМЖ
12.5 ИХ НАЯД ТӨГ

МУ-ЫН НИЙТ ГАДААД ӨР
27.9 ТЭРБУМ АМ.ДОЛЛАР

ГҮЙЛГЭЭНД БАЙГАА БЭЛЭН МӨНГӨ
895 ТЭРБУМ ТӨГ

МОНГОЛБАНКНЫ БОДЛОГЫН ХҮҮ
11%

ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2018 онд: +3.8%, 2019 онд: +4.3%
Инфляци: 2018 онд:+8%, 2019 онд +7%
Урсгал тэнцэл: 2018 онд ДНБ-ий -6.3%, 2019 онд: -7%-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2018 оны тайланд тоймлосон байна.

Эх сурвалж: https://bit.ly/2HJFlip

ДНБ-ий өсөлт: 2018 онд: +5%, 2019 онд: +6.3%
Инфляци: 2018 онд: +6.4%, 2019 онд: +6.8%,
ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2018 онд: -6.4%, 2019 онд: -8.3%- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2018 он 4-р сар) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: http://bit.ly/2zsmvYo

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 11-р сарын байдлаар 266 тэрбум төгрөгийн ашигтай гарав.

Улсын нэгдсэн төсвийн орлого өнгөрсөн жилийн мөн үеэс 27.4 хувиар, зарлага 7 хувиар тус тус өссөн бол төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 266 тэрбум төгрөгийн ашигтай гарав. Өнгөрсөн жилийн мөн үед 980 тэрбум төгрөгийн төсвийн алдагдалтай байсан хэдий ч энэ онд төсвийн орлого даруй 1.8 их наяд төгрөгөөр өссөн нь төсөв алдагдалгүй байх гол шалтгаан болж байна.



Ам.долларын ханш өмнөх сараас 17.74 төгрөгөөр нэмэгдэв.

Арваннэгдүгээр сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 133 төгрөг буюу 5.4 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 17.74 төгрөг буюу 0.6 хувиар нэмэгдэж 2581.88 төгрөг болов. 11-р сард гадаад валютын нөөц 3.4 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас 2 хувиар, өмнөх оны мөн үеэс 51.8 хувь нэмэгдсэн байна.



Инфляцийн түвшин 8.1%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2018 оны 11-р сарын байдлаар өмнөх сараас 1.8 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 8.1 хувиар, оны эхнээс 7.5 хувь өсөв. Түс сард ингэж өсөхөд хүнсний бараа, тээврийн хэрэгсэл, түлш, эм тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлгийн үнэ өсөхөд голлон нөлөөлжээ.

Гадаад худалдааны тэнцэл 1109 сая.ам доллар болов.

2018 оны арваннэгдүгээр сарын байдлаар нийт барааны эргэлт 11,852 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 23.5 хувиар өссөн бол экспорт 13.9 хувиар нэмэгдэж, импорт өмнөх оны мөн үеэс 37.5 хувиар өсч гадаад худалдааны тэнцэл 1109 сая ам.долларын ашигтай гарлаа.

ХУУДАС 2

11-Р САРЫН ОНЦЛОХ: МУ-ЫН НИЙТ ГАДААД ӨР



Эх сурвалж: www.1212.mn

2018 оны гуравдугаар улирлын байдлаар Засгийн газрын нийт гадаад өр 7 тэрбум ам.доллар, Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 27.9 тэрбум ам.доллар болсон байна. Энэ нь өмнөх улирлаас ЗГ-ын өр 2 хувь (109.1 сая ам.доллар), Улсын нийт гадаад өр 1% (230.2 сая ам.доллар)-иар тус тус өссөн байна. Харин төв банкны өр 3% буюу 68.7 сая ам.доллар, хадгаламжийн байгууллагуудын өр -2% буюу 46 сая.ам долларааp буурсан байна. Нийт гадаад өрийн 25%-ийг засгийн газрын өр, 7%-ийг Төв банкны өр, 8%-ийг хадгаламжийн байгууллагуудын өр, 28%-ийг бусад салбаруудын өр, 32%-ийг компани хоорондын зээллэгийн өр тус тус эзэлж байна.

САРЫН ОНЦЛОХ: МОНГОЛ БАНК БОДЛОГЫН ХҮҮ НЭМЭГДЭВ, 19,8 ТОННТ АЛТ ХУДАЛДАН АВАВ.

- Монголбанкны Мөнгөний бодлогын хороо Бодлогын хүүг нэг нэгж хувиар өсгөн 11 хувьд хүргэх шийдвэр гаргав. Монголбанкны тус шийдвэр нь инфляцийг дунд хугацаанд зорилтот түвшний орчимд тогтворжуулах зорилттой нийцтэй бөгөөд төгрөгийн өгөөжийг нэмэгдүүлэн, үндэсний мөнгөн тэмдэгтэд итгэх итгэлийг хамгаалж, макро эдийн засгийн дунд хугацааны тогтвортой байдлыг хадгалахад чиглэнэ. Монголбанкны Бодлогын хүүг нэг нэгж хувиар өсгөхөд зээлийн хүү 0.3 хувиар өснө. Гэхдээ бодлогын хүүг нэмснээр үндэсний мөнгөн тэмдэгтийг хамгаалах хөшүүрэг болно гэж мэдээллэв.

- Монголбанк нийтдээ 19.8 тонн алт худалдан авав. Өмнөх оны мөн үед 19.2 тонн алт худалдан авч байсан бөгөөд 3.2 хувиар нэмэгджээ. Алт худалдан авалтын дүн өмнөх оноос давж биелэсэн шалтгаан нь өнгөрөгч 10 дугаар сард аймаг, орон нутагт байгуулсан алтны сорьц тогтоох, худалдан авах нэг цэгийн төв байгуулсантай холбоотой. Ийм төв байгуулсан Дархан-Уул аймагт 107 кг, Баянхонгор аймагт 46 кг алтыг тус тус худалдан авчээ.

Эх сурвалж:

1. *Статистикийн бюллетень, 11-р сар 2018 он, Үндэсний статистикийн хороо*
2. *Статистикийн бюллетень, 11-р сар 2018 он, Монголбанк*
3. *www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn,*